



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/24

Мандалговь

Г

Г

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 14 дүгээр зүйлийн 14.2.4, Монгол улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан Угийн бичиг хөтлөх журам, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөрийн 3.4.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Иргэдийнхээ эрүүл мэнд, удам угсааг хамгаалж, элдэв гажиг, цус ойртолт, удамшлын өвчнөөс сэргийлэн, монгол хүний хөгжлийг хангах зорилгоор угийн бичгийг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд: Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэнд, хүн ам зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Боловсрол, соёл урлагийн газрын соёлын өв хариуцсан мэргэжилтэн

Музейн захирал

Төв номын сангийн захирал

Музейн арга зүйч

Төрийн бус байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга – Боловсрол, соёл урлагийн газрын соёл урлагийн

асуудал хариуцсан мэргэжилтэн

Хоёр. “Өрх бүр угийн бичгээ хөтөлцгөөе” аяныг аймгийн хэмжээнд өрнүүлэн, үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсэг /Аймгийн Засаг даргын орлогч/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны А/66 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ



020000032